

ЭМХТ-ИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ЯВЦЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Явцын хяналт-шинжилгээний үндэслэл ба арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025.01.29-ний 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, ЭМС-ын 2023 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Төвийн захирлын 2023 оны А/99 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу байгууллагын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээний зорилго


Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд явцын хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмжөөр хангахад оршино.

Гурав. Явцын хяналт-шинжилгээний дүн

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 75 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайдаар хянуулан батлуулсанаас 56% нь шинээр төлөвлөсөн, 7% нь өмнөх жилээс үргэлжлэн хийгдэж байгаа, 37% тогтмол хийгддэг ажлыг тус тус төлөвлөсөн.

Хэрэгжүүлэх хугацааны хувьд 22,6% буюу 17 нь эхний хагас жилд дуусгах, 65,4% буюу 49 нь жилийн турш үргэлжлэх, 12% буюу 9 нь 3-р улирлаас хийгдэх ажил байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 63%.



Тусгай захиалгат ажил: 5 ажил төлөвлөсөн, эхний хагас жилд дуусгах 2, хагас жилээс хойш эхлэх 1, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 71%. Үүнд:

- Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) –3
- Хангалтгүй (70 хүртэл %-тай) -1

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчин эмгэгийн тоог бууруулах зорилгоор эрүүл мэндийн ажилтанг гадаад улс оронд сургах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

Их өгөгдөл, судалгааны алба: 8 ажил төлөвлөсөн, эхний хагас жилд дуусгах 4 ажил, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 78,75%. Үүнд:

Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) –5

Хангалттай (70-85%) – 2

Хангалтгүй (70 хүртэл %-тай) – 1

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Эрүүл мэндийн статистикийн мэдээг бүртгэх, мэдээлэх журмын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

Цахим хөгжлийн алба: 14 ажил төлөвлөсөн, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 58%. Үүнд:
Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) - 3

Хангалттай (70-85%) - 6

Хангалтгүй (70 хүртэл %-тай) - 5

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Эрүүл мэндийн бүртгэлийн маягтын шинэчлэлийг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.
- Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001 стандартыг байгууллагад нэвтрүүлнэ.
- Байгууллагын цахим архивын программ хангамжийн техникийн даалгаврыг боловсруулах, цахим архив үүсгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалтыг хийнэ.
- Цахим эрүүл мэнд энтерпрайз архитектурын төсөл боловсруулна.

Хүний нөөцийн хөгжлийн алба: 19 ажил төлөвлөсөн, эхний хагас жилд дуусгах 6, хагас жилээс хойш хийгдэх 2 ажил, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 57%. Үүнд:

Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) –6

Хангалттай (70-85%) – 3

Хангалтгүй (70 хүртэл %) – 8

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үйл ажиллагааны зохицуулалтыг шинэчлэх талаар санал боловсруулж, хүргүүлнэ.
- Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэх саналыг боловсруулж хүргүүлнэ.
- Төгсөлтийн дараах сургалтын чиглэл, индексийг шинэчлэх саналыг боловсруулж, хүргүүлнэ.
- Үндсэн, төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтын гэрчилгээг цахимжуулна.
- Мультимедиа сорилын санг үүсгэнэ.
- Эрүүл мэндийн удирдах ажилтны сургалт зохион байгуулна.
- Мэргэшлийн зэргийн шалгалтыг нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажиллана.
- Ерөнхий мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагад шинээр эрх олгох ажлыг зохион байгуулна.

Тусламж үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн алба: 5 ажил төлөвлөсөн, эхний хагас жилд дуусгах 1, 3-р улирлаас эхлэх 2, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 85%. Үүнд:

Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) – 3

Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба: 9 ажил төлөвлөсөн, эхний хагас жилд дуусгах 4, хагас жилээс хойш хийгдэх 1, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 46%. Үүнд:

Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) – 1

Хангалттай (70-85%) -2

Хангалтгүй (70 хүртэл %-тай) – 5

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний зааварт нэмэлт өөрчлөлт оруулна.
- Эрхтэн шилжүүлэн суулгах нэгдсэн бүртгэл мэдээллийн санг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.
- Амьгүй донор илрүүлэх, шилжүүлэн суулгах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.
- Эрхтэн шилжүүлэн суулгуулсан иргэдийн амьдрах чадварын судалгаа хийнэ.
- Тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгах нь” зохицуулагчдад зориулсан гарын авлага боловсруулна.

Гадаад эмчилгээг зохицуулах алба: 9 ажил төлөвлөсөн, хагас жилээс хойш хийгдэх 2 ажил, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 43.5%. Үүнд:

Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) – 0

Хангалттай (70-85%) -1

Хангалтгүй (70 хүртэл %-тай) – 6

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Зайлшгүй шаардлагаар болон өөрийн хүсэлтээр гадаад улсад эмчлүүлэх үйл ажиллагааны журмын төслийг боловсруулна.
- Маш цөөн хийгддэг, өндөр зардалтай тусламж, үйлчилгээг иргэдэд үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Гадаадад эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай болон хүсэлт гаргасан иргэдийг гадаадын өндөр хүчин чадал бүхий эмнэлгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах үйл ажиллагааг зохицуулна.
- Иргэдийн гадаад эмчилгээний нэгдсэн мэдээний сан үүсгэнэ.
- Иргэдийн гадаад эмчилгээний судалгаа хийнэ.
- Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийн чиглэлээр гадаад улсын мэргэшлийн багийг урих, ажлын байрны сургалт зохион байгуулах, туршлага солилцох үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулна.

Захиргааны алба: 3 ажил төлөвлөсөн, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 67%. Үүнд:

Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) – 2

Хангалтгүй буюу огт хийгдээгүй –1

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Санхүүгийн алба: 3 ажил төлөвлөсөн, хагас жилээс хойш хийгдэх ажил –1, төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 65%. Үүнд:

Бүрэн хангалттай (85-аас дээш %-тай) – 1

Хангалтгүй (70 хүртэл %-тай) – 1

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид өгөх, Аудитаар баталгаажуулна.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад тавигдах нийтлэг болон тусгай шаардлагад нийцүүлж тайлагнах. Гүйцэтгэлийн тайлан иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, аль болох товч, тодорхой байх ёстой.

Нэг ажил үйлчилгээ, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтааж тайлагнана. Тайлагнахдаа дараах асуудлыг заавал тусгасан байна.

- Тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
- Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцлийг тодорхой дурдах

4.2. Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн үр дүн, чанарт анхаарч сайжруулах.

4.3. Төсөв хөрөнгө шаардлагатай ажлыг цаашид хэрхэх талаар удирдлагаар шийдвэр гаргуулах, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, хангалтгүй хувьтай байгаа ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

4.4. Төсөл, хөтөлбөр боловсруулж хандивлагч байгууллагад хандах, боловсруулсан журмыг батлуулах талаар хөөцөлдөх, яамны холбогдох газар, хэлтэст танилцуулах ажлыг эрчимжүүлэх.

4.5. Боловсруулж байгаа журмын төсөлд ЭМБ, мэргэжлийн нийгэмлэг холбоо, иргэдийн саналыг нээлттэй авах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА
2025 оны 7 дугаар сар

